



Ажилтны сэтгэл ханамжийн судалгаа



Bad



OK



Good



Great

Судалгааны зорилго:

Байгууллагын соёл, ажлын орчин, ажилтанд үзүүлж байгаа нийгмийн баталгаа, сургалт, дэмжлэг, хамт олон хоорондын харилцаа, хандлага, уур амьсгал, үйл ажиллагаанд сэтгэл ханамж хэр байгаа талаар тодорхойлж, үнэлэлт дүгнэлт хийж, илэрсэн алдаа дутагдлыг арилгах, цаашид сайжруулах зорилготой



Хамт олны туслалцаа



Цалин, орлого



Хамт олны уур амьсгал

Удирдлагын дэмжлэг



Карьер өсөлт

Ажлын ачаалал




Гэр бүл



Ажилтны сэтгэл ханамжийн судалгаа

Байгууллагаараа бахархах сэдэл




■ Тийм ■ Үгүй

Судалгаанд хамрагдсан нийт ажилтны 86 хувь нь өөрийн ажиллаж буй байгууллага, ажил мэргэжлээрээ бахархадаг гэсэн хариулт өгсөн байна. ажилтны сэтгэл ханамжид нөлөөлдөг чухал хүчин зүйлийн нэг нь тухайн ажиллаж буй байгууллагын нийгэмд эзлэх байр суурь, нөлөөлөл, нэр хүнд юм. Нэр хүндтэй томоохон байгууллагад ажиллаж байгаа ажилтнууд жижиг байгууллагад ажилладаг ажилтнуудаас сэтгэл ханамж нөдөртэй байдаг гэсэн олон улсын судалгаа байдаг байна.



Ажлын байрны сэтгэл ханамжийн байдал




Дүгнэлт: Нийт ажилтны 69,5 хувь нь ажлын байрны орчин нөхцөлд сэтгэл хангалуун гэсэн хариулт өгсөн байна. Үлдсэн 30.5 хувь нь ажлын орчин нөхцөл тааламжгүй гэсэн хариулт өгсөн нь ажлын байрны тохижилт, тав тухтай байдлыг үе шаттайгаар сайжруулж, ажилтны сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх шаардлагатай нь харагдаж байна


Хоорондын харилцааны сэтгэл ханамжийн байдал




Бид нэг нэгэндээ тусалдаг




Нэг нэгэндээ хүндэтгэлтэй ханддаг



Удирдлагын буруу шийдвэр алдаа, дутагдлыг шүүмжилдэг



Манай хамт олон ажлаа хэрхэн сайжруулах, үр дүнг өсгөх талаар нээлттэй ярилцдаг




■ Тийм
■ Үгүй

Дүгнэлт

Нийт судалгаанд хамрагдагсдын 80.9 хувь нь удирдлага, ажилтан хоорондын харилцаа, хандлагад сэтгэл ханамжтай байдаг гэсэн хариулт өгсөн нь байгууллагын соёл, уур амьсгалд эерэг нөлөө үзүүлж байна.



■ тийм ■ үгүй



85.7%

Судалгаанд хамрагдсан ажилтнуудын 85.7 хувь нь хамт олны уур амьсгал, байгууллагын соёлд сэтгэл хангалуун байгаа нь харагдаж байна

73%

Нийт ажилтны 73 хувь байгууллагаас зохион байгуулж буй ажилтныг хөгжүүлэх сургалтуудад сэтгэл хангалуун байдаг гэсэн хариулт өгсөн байна

ДҮГНЭЛТ

Дээрх хариултуудаас харахад байгууллагын зүгээс явуулж буй сургалтуудад ихэнх ажилтнууд сэтгэл хангалуун байгаа хэдийн ч 27 хувь нь тухайн зохиогдож буй сургалтууд хангалттай биш гэж үзсэн нь сургалтын хэрэгцээг зөв тодорхойлох, тухайн ажилтнуудад чиглэсэн зөв сургалтын хэлбэрүүдийг сонгох нь чухал гэдгийг харуулж байна.

Ажилтны нийгмийн халамж

Тийм 90.5% **Үгүй 9.5%**

Ажилтны эрүүл мэндэд тогтмол санаа тавьдаг.

Тийм 54.2% **Үгүй 45.8%**

Ажилтны ар гэрт гачигдал гарах, өвчлөх зэрэгт хангалттай тусалж дэмждэг

Тийм 33.3% **Үгүй 66.7%**


Ажилтны нийгмийн баталгааг хангалттай хангадаг

Тийм 57.1% **Үгүй 42.9%**

Би байгууллагын нийгмийн хангамж, бусад бодлогод сэтгэл хангалуун байдаг

Тийм 76.2% **Үгүй 23.8%**

Манай байгууллага ажилтнаа шагнаж, урамшуулах тал дээр хангалттай ажилладаг



Дүгнэлт: Судалгаанд хамрагдсан нийт ажилтнууд байгууллагын зүгээс ажилтнуудад үзүүлж буй нийгмийн халамж, хангамж, баталгаанд 62.2 хувь нь сэтгэл хангалуун 37.8 хувь нь ханамжгүй гэсэн хариултыг өгсөн байна. Хэдийгээр ихэнх ажилтнууд сэтгэл хангалуун байгаа ч сэтгэл ханамжийн түвшинг нэмэгдүүлэх чиглэлээр хөтөлбөр боловсруулах, хамтын гэрээ, дотоод журамд нийгмийн баталгааг хангах чиглэлээр тодорхой ажлуудыг тусгах шаардлагатай байна

Ажилтны сэтгэл ханамжид хамгийн ихээр нөлөөлж буй хүчин зүйлс

Цалингийн хэмжээ

Ажлын байрны сэтгэл ханамжид бодит орлого болох цалин хөлс нөлөөлж байгаа нь дээрх үзүүлэлтээс харагдаж байна. Хийсэн ажлынхаа үнэлгээнд тохирсон цалин урамшуулал авах нь тухайн ажилтны сэтгэл ханамжийг нэмэгдүүлдэг. Төвийн хувьд улсын төсөвт байгууллага учраас төрөөс цалинждаг, цалингийн бодлого төсвийн тухай хуулиар зохицуулагддаг хэдий ч ажилтны цалин хөлсийг тодорхой, үе шаттайгаар нэмэгдүүлэх нь ажилтны ажилдаа сэтгэл хангалуун байх

Хамт олны уур амьсгал

Ажилтнуудын сэтгэл ханамжид хамт олны уур амьсгал, байгууллагын соёл ихээхэн нөлөөлдөг нь доорх үзүүлэлтээс харагдаж байна. Ажилтан ажлын байранд хамгийн их цаг зориулдаг тул хамт олон нь түүний 2 дахь гэр бүл юм. Гэр бүл тайван байх нь тухайн хүний сэтгэл санаанд шууд нөлөөлдөг тул хамт олны уур амьсгал тухайн ажилтны хувьд ихээхэн чухал хүчин зүйл юм. Иймээс хамт олны уур амьсгалыг зөв болгох, эерэг соёлтой, байгууллагыг бүтээхэд сэтгэл ханамж нэн чухал юм

33.3%

9.5%

42.9%

14.3%



Карьер өсөлт

Сэтгэл ханамжид хувь хүний карьерийн өсөлт нь нөлөөлдөг гэж судалгаанд оролцсон ажилтнуудын 9.5 хувь нь хариулсан байна. Манай байгууллагын хувьд хувь хүний карьер хөгжлийг дэмжих бодлого байхгүй ч төрийн байгууллагын мэрит зарчмыг баримтлан ажилдаа идэвх санаачлагатай ажиллаж байгаа ажилтнуудаас албан тушаалд дэвшүүлэн ажиллуулах бодлогыг хэрэглэх нь зүйтэй

Удирдлагын дэмжлэг

Ажилтны сэтгэл ханамжид удирдлагын дэмжлэг, туслалцаа чухал ач холбогдолтой гэж судалгаанд оролцсон ажилтнуудын 14.3 хувь нь хариулжээ. Удирдах албан тушаалтан ажилтнуудад мэргэжил арга зүйн зөвөлгөө дэмжлэгийг байнга өгч, хийсэн ажлын үр дүнг ил тод нээлттэйгээр урамшуулж байх нь ажилтны сэтгэл ханамжийг нэмэгдүүлж, идэвхижүүлдэг

Сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх арга зам

Ажилтны нийгмийн баталгааг хангах, хүртээмжтэй цалин хөлс олгох, үл ялгаварал, тэгш хандлага, удирдлагын дэмжлэг, хамт олны харилцаа зэрэг байх нь сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх чухал хүчин зүйлс юм.




Тогтвортой ажлын байр



Тасралтгүй сургалт




Хүртээмжтэй цалин хөлс



Зөв карьер төлөвлөлт



Тэгш харилцаа, хандлага



Шагнал, урамшуулал



Тав тухтай ажлын орчин



Техник хэрэгслийн бүрэн хангалт



Удирдлагын дэмжлэг

